## ОЙЖУУЛАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

| | Шалгуур |
|---|---|
| Ойжуулалтын ажил гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахад харгалзах үзүүлэлтүүд | "Мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх" чиглэлээр ойн мэргэжлийн байгууллагын эрхтэй байх. |
| | Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааны тайланг гэрэл зургаар баталгаажуулах. |
| | Ойжуулалтын ажил хийх мэргэжлийн боловсон хүчинтэй байх. Мэргэжлийн боловсон хүчний диплом, мэргэжлийн үнэмлэх, ажилд орсон тушаал, хөдөлмөрийн гэрээ. (тэдгээрийг баталгаажуулах) Удирдах болон инженер техникийн ажилтнуудын мэдээлэл, мэдэгдэл. |
| | Ойжуулах ажилд шаардагдах шаардлага хангасан стандартын тарьцны нөөцтэй байх. Стандартын шаардлага хангасныг нотлох баримт, материалыг ирүүлэх. |
| | Сүүлийн 2 жилд хийсэн ойжуулалт болон адил төстэй ажлын үр дүн. (акт, гэрээний хувь, тайланг хавсаргах) |
| | 1 га талбайг ойжуулахад шилмүүст модны тарьц 2500-аас доошгүй байхаар тусгаж өгнө. |
| | Ойжуулалтын ажилд шаардлагатай ажлын багаж, хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл түүнийг гэрэл зургаар баталгаажуулах. Автомашин түрээслэх гэрээ, үнэмлэх, баримт бичиг. Багаж тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт. |
| | Тарьц, суулгацын амьдралтыг дээшлүүлэх арга технологи, төлөвлөлт. |
| | Ойжуулалтын ажил болон, таримал ойг арчлах хамгаалах, талаар захирлын болон ерөнхий инженерээр баталгаажуулсан технологийн карттай байх. |
| | Ажил гүйцэтгэх төлөвлөгөө, график, ажлын төсөв. (баталгаажуулах) |
| Бэлтгэл ажил | Ойжуулах, мод тарих талаар орон нутгийн иргэдэд зориулсан сургалт сурталчилгааг өргөнөөр хийх, иргэдийг татан оролцуулах. |
| | Ойжуулах ажлын технологийн картыг боловсруулж батлуулах. |
| | Ойжуулах талбайг тусгаарлах, тэмдэглэх, өнцөгүүдэд шон босгох. Тусгаарласан талбайн захын цэгүүдийн солбицолыг GPS-ээр хэмжсэн байх. |
| | Ойжуулах талбайг цэвэрлэх, бэлтгэх, шан, талбар гаргах, чиг тэмдэг тавих. |
| | Суулгах материалыг ачих буулгах, түр хадгалах технологи, горим. |
| Үндсэн ажил | Завхан аймгийн Идэр сумын нутагт 28.7 га талбайд ойжуулалтын ажил хийнэ. |
| | Тарих талбайн хөрс бэлдэх. |
| | Суулгах материалыг тарилтанд бэлдэх. |
| | Баталгаажуулсан технологийн картын дагуу тарилт хийх, услах, арчлан хамгаалах. |
| Усалгаа, хамгаалат, нөхөн тарилт хийх | Ойжуулах талбайд тарилт хийхдээ бороо угтуулах, тарьсны дараах усалгааг заавал хийх талаар тусгах. |
| | Ургах чадваргүй болсон тарьц, суулгацыг ухаж авах, нөхөн тарилт хийх талаар тусгаж өгөх. |
| | Таримал ургамлыг 3 жилийн туршид арчлах, гадны хүчин зүйлээс хамгаалах. |
| | Ойжуулсан талбайд мал бэлчээхийг хориглосон анхааруулга самбар байрлуулах. (ойжуулсан талбайн хэмжээ, гүйцэтгэсэн ААН-ийн нэр, огноо зэргийг тусгасан байх) |
| Тайлан боловсруулалт-ын ажил | Ойжуулалтын ажлын тайланг захиалагчид 2% ирүүлнэ. Тайлан дор дурдсан бүрдэл хэсэгтэй байна.<br>1. Ойжуулалтын ажлын бичмэл тайлан.<br>2. Ойжуулалт хийх үеийн гэрэл зургууд.<br>3. Ажилласан иргэдийн нэрсийн жагсаалт, регистрийн дугаарын жагсаалт<br>4. Ойжуулсан талбайн зураг, захын цэгүүдийн солбицлуудын хамт. (GPS-ээр хэмжсэн) |
| Ажил гүйцэтгэх төсөв | Хорин сая төгрөг (20000000).<br>1га талбайг ойжуулах норматив зардал зургаан зуун ерэн таван мянган төгрөг (695000). |

Боловсруулсан: Ойн албаны дарга [signature] Д.Банзрагч